

ЕРӨНХИЙ ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:



ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:



**БУЛГАН АЙМГИЙН БУЛГАН СУМЫН ЗАСАГ ДАРГА Д.БЯМБАЖАРГАЛЫН ИВЭЭЛ ДОР
ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНИЙ МАСТЕР Г.БАТЖАРГАЛ АГСНЫ НЭРЭМЖИТ
ОЛИМПЫН ТАЕКВОНДОГИЙН 2025 ОНЫ "ЗХЗ БАГИЙН ТУЛААНЫ УАШТ"**



ЗХЗ

БАГИЙН ТУЛААНЫ УАШТ

БУЛГАН АЙМАГ | 2025.08.18-20

ДЭМЖИГЧ БАЙГУУЛЛАГА:



Asgat Trade LLC



**БУЛГАН АЙМГИЙН БУЛГАН СУМЫН
ЗАСАГ ДАРГА Д.БЯМБАЖАРГАЛЫН ИВЭЭЛ ДОР
ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНИЙ МАСТЕР
Г.БАТЖАРГАЛ АГСНЫ НЭРЭМЖИТ
ОЛИМПЫН ТАЕКВОНДОГИЙН 2025 ОНЫ
“ЗХЗ БАГИЙН ТУЛААНЫ УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН”
ЗААВАР**

ТЭМЦЭЭНИЙ ЗОРИЛГО:

- Таеквондогийн спортыг сурталчлах

ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:

Зохион байгуулагч	Монголын таеквондогийн холбоо
Хамтран зохион байгуулагч	Булган аймгийн Засаг даргын тамгын газар Булган аймгийн хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар Булган аймгийн Биеийн тамир, спортын газар Булган сумын Засаг даргын тамгын газар Булган аймгийн спортын төрөлжсөн сургалттай ерөнхий боловсролын сургууль Булган аймгийн Бүргэд клуб
Холбоо барих утас	7015-5500, 9696-2288, 9969-6084
Имэйл	mongoliataekwondo@gmail.com
Хаяг	Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Спортын төв ордон

ТӨЛӨВЛӨГӨӨТ ХУВААРЬ:

Огноо	Хөтөлбөр	Байршил
08-р сарын 01-11	Бүртгэл	www.mongol-taekwondo.com
08-р сарын 17	Техникийн зөвлөгөөн	Булган аймаг
	Жин үзэлт	
08-р сарын 18-20	Тэмцээн	

- ❖ Бүртгэл хаагдсаны дараа тэмцээний дэлгэрэнгүй хуваарь нийтэд зарлагдах ба тэмцээнд оролцогчдын тооноос хамаарч өдөрт өөрчлөлт орж болзошгүй.

ШААРДЛАГА:

Тэмцээнд оролцогч **Тамирчдал** Монголын таеквондогийн холбооны дүрэм, журмын дагуу дараах шаардлага тавигдана.

1. Оролцогч тамирчин Монголын таеквондогийн холбоо болон Куккивоны ямар нэг зэрэг хар бүс, дантай байна
2. Тамирчин нь Монголын таеквондогийн холбооны цахим бүртгэлийн системд бүртгүүлсэн байх шаардлагатай байх ба хүчинтэй лицензтэй байна
3. Тамирчид шилбэ, шуу, шүд /өнгөгүй тунгалаг эсвэл цагаан өнгөтэй/, эмзэг эрхтний хамгаалалт болон KPNP цахим мэдрэгчтэй оймсыг бэлдэж ирэх шаардлагатай
4. Бага нас, өсвөр үеийн тамирчид тулааны үеэр нүүрний касктай тулалдана

Багт тавигдах шаардлага:

1. Тэмцээнд оролцох байгууллага нь Монголын таеквондогийн холбооны албан ёсны гишүүн байгууллага байна
2. Оролцогч байгууллага нь татвар, хураамжийн үлдэгдэл тооцоогүй байх
3. Багууд өөрийн сургалтын төвийн нэр дээр эсвэл ивээн тэтгэгчийн байгууллагын нэр дээрээс тэмцээнд оролцоно

Дасгалжуулагчид тавигдах шаардлага:

1. Монголын таеквондогийн холбооны дасгалжуулагчийн В зэрэгтэй эсвэл олон улсын дасгалжуулагчийн эрх бүхий дасгалжуулагч тамирчдыг дэвжээнд авч гарах эрхтэй
2. Хагас шигшээ болон шигшээ тулааны үеэр дасгалжуулагчид албаны хувцас өмсөх шаардлагатай
3. Тэмцээнд оролцохоор хүрэлцэн ирэх, буцах замд болон тэмцээний үеэр хариуцсан тамирчдынхаа аюулгүй байдалд хяналт тавих нь тухайн багийн дасгалжуулагчийн үүрэг
4. Тэмцээний үеэр дасгалжуулагч нь ямар ч төрлийн малгай өмсөхийг хориглоно

1. НАСНЫ АНГИЛАЛ БА НИЙЛБЭР ЖИН /4 ТАМИРЧИН/

Нас	Эрэгтэй баг	Эмэгтэй баг
Бага нас 8-9 нас	124кг	120кг
Бага нас 10-11 нас	150кг	146кг
Өсвөр үе 12-14 нас	217кг	197кг
Залуучууд 15-17 нас	266кг	240кг
Насанд хүрэгч 18-29кг	307кг	261кг
Мастер +30 нас	337кг	283кг

Сэлгээний тамирчин буюу 4 дэхь тамирчин жин үзүүлэх шаардлагатай ба тухайн багийн нийлбэр жин нь заасан жингийн хязгаарт багтсан байх шаардлагатай.

2. НАСНЫ АНГИЛАЛ БА НИЙЛБЭР ЖИН /3 ТАМИРЧИН/

Нас	Эрэгтэй баг	Эмэгтэй баг
Бага нас 8-9 нас	110кг	105кг
Бага нас 10-11 нас	120кг	115кг
Өсвөр үе 12-14 нас	175кг	160кг
Залуучууд 15-17 нас	215кг	185кг
Насанд хүрэгч 18-29кг	250кг	204кг
Мастер +30 нас	250кг	204кг

3. ТЭМЦЭЭНИЙ ДҮРЭМ:

2.1 Багийн тулааны тэмцээн KPNP цахим онооны системээр явагдана.

2.2 Баг бүр тэмцээнд гарааны 3 тамирчин, 1 сэлгээний тамирчинг томилно. Тамирчдыг 1 (хамгийн хөнгөн) -4 (хамгийн хүнд) хүртэл дугаарлана.

2.3 Тэмцээн нь 3 үе шаттайгаар (1-р үе 3 минут, 2-р үе 3 минут, 3-р үе 3 минут), үе хооронд 1 минутын завсарлагатайгаар явагдана.

2.4 1-р шат нь уламжлалт багийн тоглолтын хэлбэрийг үндэслэн тамирчид өөртэй нь ижил дугаар бүхий өрсөлдөгч багийн тамирчинтай таарч тус бүр 1 минут тулалдана. Энд багийн тамирчдын дугаарлалт багаас их хүртэлх дарааллаар буюу хөнгөн жингийн тамирчнаас хүнд жингийн тамирчин хүртэлх дарааллаар явагдана. Багийн тамирчин тус бүрийн авсан онооны нийлбэр нь тухайн багийн оноо болж бүртгэгдэнэ.

2.5 2-р үед тухайн хоёр багийн тулаан эхлэхээс өмнө багийн дасгалжуулагчийн ирүүлсэн 3 тамирчны дарааллаар 3 минутын турш тулаан явагдана.

2.6 3-р үед 3 минутын туршид багийн дасгалжуулагчийн санал болгосон тамирчнаа ээлжлүүлэн тулалдана. Үеийн туршид тамирчдын дарааллаас үл хамааран тухайн багийн гурван тамирчин хүн нэг бүр хамгийн багадаа нэг удаа тулалдсан байхыг шаардана. Ингэхдээ дараах үндсэн дүрмийг дагана.

- 2-р үеийн төгсгөлд тулалдсан 2 тамирчин 3-р үеийг эхлүүлэн тулалдана.
- Тулааны явцад аливаа тамирчин нь хамгийн багадаа 15 секунд дэвжээн дээр тулалдсаны дараа солигдох эрх нээгдэнэ. Энэхүү хугацааг хоёр булангийн цагчин шүүгчид хариуцна.
- Энэ үед багийн тамирчин тус бүр хамгийн багадаа нэг удаа дэвжээнд гарч тулалдсан байхыг шаардана. Хэрэв заавал тулалдах ёстой 3 тамирчны нэг нь тулалдалгүйгээр үеийг дуусгасан болохыг эсрэг баг нь мэдэгдэж, түүнийг нь шүүгчид хянан үзээд батлагдвал тухайн багийг хожигдсонд тооцно.
- 1, 2, 3-р үед нийлбэр оноогоор илүү оноо авсан багийг ялагчаар тодруулна. Хэрэв 3 үеийн дараа оноо тэнцсэн тохиолдолд тамирчин солилцооны зарчмаар дээд тал нь 3 минут тулалдуулна. Ингэхдээ түрүүлж 4 оноо авсан багийг ялагчаар тодруулна.

- Торгуулийн тоонд хязгаар тавигдахгүй.
- Багийн тулаанд онооны илт давуу ялалт гэсэн ойлголт байхгүй.
- Нэг нас, хүйсийн ангилалд найм буюу түүнээс дээш баг өрсөлдөж байгаа бол хэсгийн шатнаас шигшээ тоглолт хүртэл хасагдах системээр явуулна.
- Нэг нас, хүйсийн ангилалд долоо буюу түүнээс цөөн тооны баг оролцсон тохиолдолд хагас шигшээ хүртэл тойргоор өрсөлдөж хагас шигшээ, шигшээ тоглолт хасагдах системээр явагдана.
- Таваас долоон баг оролцож байгаа бол санамсаргүй аргаар хоёр хэсэгт хуваагдана. Хэсэг тус бүрт багтаж буй багууд хоорондоо тойргоор тулалдаж хамгийн өндөр оноо авсан хоёр баг хагас шигшээд шалгарна.
- Хэсгийн шатанд хожсон баг 3 оноо, хожигдсон бол 0 оноо авч бүх тойргийн тоглолтын дараа хамгийн өндөр оноо авсан баг хагас шигшээд шалгарна.
- Хагас шигшээд хамгийн өндөр оноо авсан баг хамгийн бага оноо авсан нөгөө хэсгийн багтай учраа таарна. Оноо тэнцсэн тохиолдолд дараах зарчмыг баримтална:
 - Багийн авсан онооноос эсрэг багийн авсан оноог хасаад илүү их оноо цуглуулсан баг
 - Хэрэв багуудын оноо тэнцсэн хэвээр байх тохиолдолд торгуулийн тоо багатай багийг ялсанд тооцно
 - Хэрэв багуудын оноо тэнцсэн хэвээр байх тохиолдолд тэмцээний ерөнхий шүүгч багийн оноолтыг бүрэн эрхийн хүрээнд шийднэ.
- Баг бүр тулалдахаас гучин (30) минутын өмнө шалгагч шүүгчийн хэсэгт очсон байх үүрэгтэй.
- Баг бүрийн оролцогчдын цээжний хамгаалалтын хэсэгт эрэмбийн тоо бүхий дугаарыг таних зорилгоор байрлуулна. Сэлгээний тамирчинд “4” гэсэн тоо өгнө.
- Баг тус бүрт гурван (3) гарааны тамирчин, нэг (1) сэлгээний тамирчин, хоёр (2) дасгалжуулагч, нэг (1) багийн эмч хамт байж болно.

4. СЭЛГЭЭНИЙ ТАМИРЧИН:

3.1 1-р үеийн дараа багийн гурван (3) тамирчны аль нэгийг нь нэг удаа сольж болно.

3.2 Тэмцээний үеэр багийн тамирчид бэртэл авч хамгийн багадаа гурван тамирчин бүхий бүтэн багаар өрсөлдөх боломжгүй болсон тохиолдолд тухайн багийг хожигдсонд тооцно.

5. БАГ БҮРДҮҮЛЭЛТ:

4.1 Бага нас, өсвөр үе, залуучуудын насны багийн ангилал тус бүрд Монголын таеквондогийн холбооны гишүүнчлэлтэй бусад клубээс зөвхөн нэг тамирчинг өөрийн багт шилжүүлж авч болно.

4.2 Насанд хүрэгчид болон мастер ангилалд дээд тал нь хоёр хүртэлх сургалтын төв нэгдэн нэг багийг бүрдүүлж болно. Ингэхдээ дараах зарчмыг баримтална.

- 2021 оноос хойш Үндэсний шигшээ багт харьяалагдаж байсан тамирчид хамтдаа нэг багт байж болохгүй.
- Бүх цаг үед Үндэсний шигшээ багт харьяалагдаж байсан тамирчид нэг багт хоёроос илүүгүй байна.

6. БҮРТГЭЛ:

- I. Бүртгэлийг цахимаар хийх ба Монголын таеквондогийн холбооны албан ёсны бүртгэлийн систем болон www.mongol-taekwondo.com хаягаар бүртгүүлнэ.
- II. Оролцогчийн хураамжийг зөвхөн цахимаар шилжүүлнэ.

7. ОРОЛЦОГЧИЙН ХУРААМЖ, БҮРТГЭЛИЙН ХУГАЦАА:

- I. Бүртгэлийн хугацаа: 2025 оны 08-р сарын 01-11-ний өдрийн 18:00 цаг хүртэл
 - Улаанбаатар хот болон Булган аймгийн тамирчид дэвжээний төлбөр 600.000 (зургаан зуун мянга) төгрөг
 - Булган аймгаас 1000 км дотогш 400.000 (дөрвөн зуун мянга) төгрөг
 - Булган аймгаас 1000 км гадагш 300.000 (гурван зуун мянга) төгрөг

8. ШАГНАЛ УРАМШУУЛАЛ:

Насны ангилал тус бүрд эхний гурван байр эзэлсэн багийн тамирчдыг байр эзлүүлж урамшуулна.

- 1-р байр Алтан медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал
- 2-р байр Мөнгөн медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал
- 3-р байр Хүрэл медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал

9. ӨМСГӨЛ:

- Монголын таеквондогийн стандартад нийцсэн өмсгөл өмсөн тэмцээнд оролцох шаардлага тавигдах хэдий ч багийн нэр, логог /ивээн тэтгэгчийн/ тулааны өмсгөл болон жигдрэлийн хувцсан дээр хадахыг зөвшөөрнө.

- Тэмцээний өмсгөлийн стандарт



10. БАГИЙН АХЛАГЧДЫН УУЛЗАЛТ БОЛОН СУГАЛАА

1. Багийн ахлагч нар 08-р сарын 17-ны өдөр хуралдана.
2. Багийн ахлагчдын уулзалтад тэмцээнд оролцох багууд төлөөллөө оролцуулах үүрэгтэй.

- ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРОО -